



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/36

Мандалговь

Коронавируст халдвар (Ковид-19)-аар
өвчилсөн хүүхдэд нийгэм сэтгэлзүйн
дэмжлэг үзүүлэх тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 19 дүгээр зүйлийн 19.1.1, 19.1.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйл, 11.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрдэнэдалай, Өлзийт сумын хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19)-аар өвчилсөн, тусгаарлагдсан хүүхдүүдэд үзүүлэх нийгэм, сэтгэлзүйн дэмжлэгт шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн мэдээллийг бүртгэн, нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхэд, гэр бүлд нийгэм, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, тусламж, дэмжлэг үзүүлэх ажлыг хүүхдэд ээлтэй, хүний эрхийг дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулж ажиллахыг хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг), хамгаалах байрны арга зүйч, сэтгэлзүйч (Г.Отгонсүрэн), гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч (Б.Бүжинлхам) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 291700 (Хоёр зуун ерэн нэгэн мянга долоон зуун) төгрөгийн зардлыг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж, ажиллахыг хүүхэд хамгааллын мэргэжилтэн (Б.Цэцэг)-д даалгасугай.


ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190073

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 04 дугаар сарын 24-ны өдрийн
А/36 тоот тушаалын дүгээр хавсралт



НИЙГЭМ СЭТГЭЛЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХЭД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Хэрэглэгдэхүүн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Буддаг ном	ш	6	2,000.00	12,000.00
2	Харандаан будаг	хайрцаг	6	2,800.00	16,800.00
3	Хүрч мэдэрдэг ном	ш	4	9,900.00	39,600.00
4	Сэтгэл хөдлөл хөгжүүлэх ном	ш	2	5,900.00	11,800.00
5	Танин мэдэхүйн ном	ш	6	13,000.00	78,000.00
6	Сургамжит өгүүллэг	ш	4	13,900.00	55,600.00
7	Хүний хөгжлийн ном	ш	1	20,000.00	20,000.00
8	Тэмдэглэлийн дэвтэр	ш	11	2,800.00	30,800.00
9	Бал	ш	11	2,000.00	22,000.00
10	Ил захидал	ш	17	300.00	5,100.00
Нийт					291,700.00

-----oOo-----

